



**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2022 оны ээлжит 10 дугаар хуралдааны  
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2022 оны ээлжит 10 дугаар хуралдаан 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр холимог оролцоотой (биеэр болон цахим) хэлбэрээр болов.

Энэхүү хорооны хуралдаанаар "Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт"-ын баримт бичгийн төслийн тухай (Хорооны 2022 оны 07 дугаар хуралдааны тэмдэглэл болон 2022 оны ээлжит 6, 7 дугаар хуралдаанаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын тухай); Радио давтамжийн хяналтын үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, цаашдын зорилтын талаар танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ олгох, өөрчлөлт оруулах, шилжүүлэх, хүчингүй болгох) асуудлыг хэлэлцэж, нийт 5 тогтоолыг батлан шийдвэрлэв.

ХХЗХ-ны 2022 оны ээлжит 10 дугаар хуралдаанд хорооны 2022 оны 07 дугаар хуралдааны тэмдэглэл, хорооны ээлжит хуралдаанаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын хэрэгжилт, "Хөдөлгөөнт холбооны 5G сүлжээний радио давтамжийн хуваарилалт ба зохицуулалт"-ын баримт бичгийн төслийн 3 дахь хувилбарыг хэлэлцүүлэв. Тус хуралдааны үеэр хорооны дарга, нэр бүхий гишүүдээс өгсөн зөвлөмж, саналаар боловсруулсан баримт бичгийн төслийг хорооны гишүүдэд цахимаар, эрх ашиг нь хөндөгдөж байгаа хуулийн этгээд, үйлчилгээ эрхлэгч нарт албан тоотоор хүргүүлэх, санал авах, холбогдох талууд баримт бичгийн төслийн талаар нэгдсэн зөвшилцөл тохиролцож эцэслэн боловсруулах, хорооны хуралдаанд хэлэлцүүлэхийг РДХЗГ /3.Амгалан/-т даалгав.

Зохицуулах хорооны 2022 оны ээлжит 10 дугаар хуралдаанд РДХЗГ-аас Радио давтамжийн хяналтын үйл ажиллагаа, Радио өргөн нэвтрүүлэг, давтамжийн хяналтын төв (РӨНДХТ)-ийн чиг үүргийн хэрэгжилтийн талаар танилцуулга, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төсөл, саналыг сонсов. Хуралдаанаас хяналтын төвийн үйл ажиллагааг өргөжүүлэх; хил орчим, үүрэн холбоо, өргөн нэвтрүүлэг, уул уурхай, барилга, үйлчилгээний байгууллагын радио давтамжийн ашиглалт, үйлчилгээнд тавих хяналт шалгалт, нөлөөллийн хэмжилтийн үр дүнгийн хэрэгжилтэд анхаарах; цаашид төрийн (МХЕГ) хяналтын тогтолцооны өөрчлөлттэй төв нь ажлаа яамтай уялдуулах; 2016 оноос хойш Монгол улсад радио долгионы хяналт, баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх төслийг гадаадын зээлээр төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа боловч өнөөг хүртэл хугацаа алдаж, радио долгионы хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх чадавх, боломжийг сайжруулах шаардлага гарч байгаа зэргийг харгалзан байгууллагын өөрийн хөрөнгө, зардлаар үе шаттай шийдвэрлэх асуудлыг боловсруулж, хорооны 2023 оны төсөв, төлөвлөгөөнд тусган 2022 оны 12 сард багтаан хорооны хуралдаанд танилцуулахыг үүрэг болгов.

Хорооны 2022 оны ээлжит 10 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ олгох, өөрчлөлт оруулах, шилжүүлэх, хүчингүй болгох) холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 5 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 5 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, 12 дугаар зүйл, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 48 тоот тогтоолын хавсралтаар 6 хуулийн этгээдэд 6 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.15 дах заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 5.1.1 дэх заалт болон 5.3 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 49 тоот тогтоолоор 2 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулсан;
- Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.6, 5.7 дах хэсгийг тус тус үндэслэн 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 50 тоот тогтоолоор 2 хуулийн этгээдэд 2 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дах заалт, 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дах заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 51 тоот тогтоолын хавсралтаар 3 хуулийн этгээдийн 4 тусгай зөвшөөрөл, хорооны 52 тоот тогтоолоор (Би энд би пикчерс ХХК) 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо  
2022-10-25